



СҮМБЭР СУМЫН ИРГЭН
Б.БАТЗАЯА ТАНАА

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас: 7054 3063, Цахим шуудан: baigal@gs.gov.mn

2024.03.01 № 55
танай _____-ны № _____-т

Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай

Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах тухай таны ирүүлсэн хүсэлтийн дагуу Сүмбэр суманд хэрэгжих “Авто зогсоол, худалдаа үйлчилгээний төв барих” төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр уг төслийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэх хугацаанд ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан онцгойлон анхаарах чиглэлд заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ

4224020009

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС**

2024 оны 03 сарын 01

Говьсүмбэр аймаг

Төслийн дугаар:

Дугаар 2024/02

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: Б.Батзаяа, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1 дүгээр байг, ХБ-17 тоот. Регистрийн дугаар: ЕЙ91033110.

Төслийн нэр: “Авто зогсоол, худалдаа үйлчилгээний төв барих” төсөл

Төслийн хүчин чадал: Уг төслийн хүрээнд 20-30 том оврын ачааны машин зогсох хүчин чадалтай, бүрэн камержсан авто зогсоол болон дугуй засвар, үйлчилгээний төв, бие засах газар шинээр барихаар төлөвлөсөн.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, Гомбосүрэн ноёны өргөн чөлөө 1 гудамжны 100а тоот. /Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаартай захирамжаар 0.5 га газрыг эзэмшсэн/

Холбоо барих утас, имэйл хаяг: 94189419, 88769419

Орон нутгийн санал: Сүмбэр сумын Засаг даргын 2021 оны 12 сарын 21-ний өдрийн А/732 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзав.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт	Тийм	-	-	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2, 7.3, 7.4 дэх заалтууд
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	тийм	-	-	-
	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын	тийм	-	-	Хуулиар хамгаалагдсан нутаг дэвсгэрт байрлаагүй.

Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)				
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх	тийм	-	-	Говьсүмбэр аймаг нь байгалийн мужлалын хувьд говь хээрийн талархаг их мужид оршдог. Цөлжилтөд өртөх магадлал өндөр.
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх	тийм	-	-	-
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	тийм	-	-	-
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах эсэх	тийм	-	-	Авто тээврийн хэрэгслийн нөлөөгөөр бохирдол үүснэ.
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх	тийм	-	-	-
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны	тийм	-	-	-

нөөцийн хомсдол үүсэх, эсэх				
Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх	тийм	-	-	-
Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх эсэх	тийм	-	-	Шатах, тослох материал хөрсөнд асгарах тохиолдолд бохирдол үүснэ.
Хөрсөн бүрхэвч				
Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх	-	тийм	-	Тээврийн хэрэгслийн нөлөөгөөр хөрс эвдрэлд орох эрсдэлтэй.
Хөрс бохирдуулах эсэх	тийм	-	-	Шатах, тослох материал, хог хаягдлын нөлөөгөөр хөрс бохирдох эрсдэлтэй.
Хөрс доройтох, цөлжих эсэх	-	тийм	-	-
Ургамлан нөмрөг				
Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх	тийм	-	-	Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг устана.
Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх	тийм		-	Ховор, нэн ховор ургамлын тархац нутагт байрлаагүй.
Амьтны аймаг				
Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх	тийм	-	-	-
Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх	тийм		-	-
Нутгийн оршин суугчид				

Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх	тийм	-	-	-
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөтэй эсэх	тийм	-	-	-
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа эсэх	-	тийм	-	-
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх	тийм	-	-	-
	Түүх, соёлын биет өв				
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх соёлын үнэт зүйлс бий эсэх	тийм	-	-	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх соёлын үнэт зүйл байхгүй.
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх	тийм	-	-	Тос, тосолгооны материалыг хадгалах, ашиглахад аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан ажиллах шаардлагатай
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх	тийм	-	-		

Нэгдсэн дүгнэлт:


Тус аймгийн Сүмбэр сумын нутагт хэрэгжих "Авто зогсоол, худалдаа үйлчилгээний төв барих" төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөл нь байгаль орчныг хамгаалах тухай багц хууль, байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэртэй зөрчилдөөгүй, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн анхан шатны буюу урьдчилсан үнэлгээний шалгууруудаар болзошгүй сөрөг нөлөөтэй боловч, тодорхой нөхцөлүүдийг даалгаж, төслийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.


Онцгойлон анхаарах зүйлс:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх
2. Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.4 дэх заалтын дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж байх.
3. Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6 дахь заалтын дагуу төсөл хэрэгжих талбайн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлж орон нутгийн онцлогт тохирсон мод бут, зүлэг тарих, усалгаа, арчилгааг тогтмол хийж байх

4. Төслийн талбайд хөрсний бохирдол, эвдрэл үүсэхээс урьдчилан сэргийлж төслийн зам, талбайг хатуу хучилттай болгох
5. Хог хаягдлын тухай хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах.
6. Төслийн үйл ажиллагаанаас гарах энгийн болон аюултай хог хаягдал, дахивар хог хаягдлыг ангилан ялгаж аюултай хог хаягдлыг түр хадгалах, шилжүүлэх, дахивар хог хаягдлыг дахивар авах цэгт хүргэх
7. Төслийн талбайд стандартын шаардлага хангасан зориулалтын хогийн сав байршуулах
8. Хог хаягдлын тухай хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хөрс бохирдуулагч жорлон байгуулахыг хориглосон тул Ариун цэврийн газрыг холбогдох стандартын дагуу байгуулж үйл ажиллагааны явцад ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийх
9. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулж үүссэн энгийн хог хаягдлаа тогтмол зайлуулж байх.
10. Хог хаягдлыг ил задгай шатаахгүй байх, зориулалтын бус газарт хатуу болон шингэн хог хаягдал хаяхгүй байх.
11. Эзэмшил газрын 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг тогтмол цэвэрлэж байх
12. Барилга байгууламж барих үед түгээмэл тархацтай ашигт малтмалыг орон нутгаас ашиглах тохиолдолд Сүмбэр сумын ЗДТГ-аас зөвшөөрөл авч ашиглах
13. Онцгой байдлын газартай хамтран гамшиг осол, галын аюулаас хамгаалах төлөвлөгөөтэй ажиллах, албан хаагчдад тогтмол сургалт зохион байгуулах. Галын аюулаас хамгаалах дүрэм, журмыг мөрдөж ажиллах
14. Холбогдох салбарын аюулгүй ажиллагааны дүрэм, журам, норм, нормативыг баримтлан ажиллаж ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах
15. Багийн Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хуулийн хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлэх.
16. Дээрх онцгойлон анхаарах чиглэлд тусгагдсан арга хэмжээнүүдийг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган жил бүр батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах


Дээр дурдсан нөхцөл болзлыг хэрэгжүүлж ажиллаагүй, байгаль орчны хууль, тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.

Хянасан: Ерөнхий үнэлгээний шинжээч бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Гарын үсэг:  Д.Мөнх-Эрдэнэ

Ерөнхий үнэлгээ хийсэн:
 Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
Гарын үсэг:  Н.Намуунцэцэг

2024.03.01

Ерөнхий үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрсөн:

Овог, Нэр: Б.Батзаяа
Албан тушаал: Сүмбэр сумын иргэн
Гарын үсэг: 

2024.03.01